



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар	7
2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал.....	10
3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	10
3.2 Бэлэг дурсгалын барааны зарцуулалттай холбоотой асуудал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18
6. Албан шаардлага	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 845
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С БҮРЭНБАТ





Аудитын тайлан

2.1. Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Л.Оюун-Эрдэнэ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулж байх, бэлэг дурсгал бэлтгэх журам боловсруулан мөрдөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар гүйцэтгэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн ХЭГ/880 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Тус байгууллага 2018 онд Засгийн газрын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх албан даалгавар, “2018 оныг хариуцлагын жил” болгох зорилго дэвшүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд 6 зорилтын хүрээнд 303 арга хэмжээ төлөвлөн ажилласан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандартын дагуу бүрэн шинэчлэгдээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.



Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

Харин үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын алба нь харьяа 1 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж 12 зөвлөмж өгсөн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 34,375.1 сая төгрөгийн 2.0 хувь буюу 687.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтээр дахин тооцоход нийт зардал 44,383.0 сая төгрөгийн 2 хувь буюу 887.7 сая төгрөг байна.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй, эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 14 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан байна.



үснэгт №1. Санхүүгийн тайлангийн аудит хэлбэр /тоогоор/

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	-
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	5		-	-
3	Төсөл хөтөлбөрийн нэгж	3		-	-
Дүн		10	4		

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/156 дугаар тушаал

Аудитаар харьяа 10 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын компаниар гэрээгээр аудит гүйцэтгүүлж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,467.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 97.1 хувь буюу 5,310.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1.5 хувь буюу 79.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 1.4 хувь буюу 77.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт. /сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Үүнээс:									
		Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагч	12	65.8			3	9.0	9	56.8	-	-
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	10	79.6	-	-	2	70.8	8	8.8	-	-
3	Төсөл хөтөлбөрийн нэгж	2	12.2	-	-	-	-	2	12.2	-	-
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	2	-	-	-	-	-	2	-	-	-
Дүн		26	157.6	-	-	5	79.8	21	77.8	-	-

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа зөрчлөөс материаллаг алдаа зөрчлийг дурдвал:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар цалингийн зардлаас 20.4 сая төгрөгийн тэмцээн уралдааны шагнал болон мөнгөн шагнал олгосон;
2. Ерөнхий сайдын ажлын алба анхан шатны баримтын бүрдэл дутуу 13.4 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд тусгасан;
3. Засгийн газрын автобааз



- Бэлэн мөнгөөр түрээс болон гараашны төлбөр, тээврийн хөлс, цалингийн урьдчилгааны буцаан төлөлт зэрэг 55.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, касст бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байхад 10.0 сая төгрөг харилцахаас авсан;
 - Жилийн эцсийн байдлаар 11 байгууллага, хувь хүнтэй холбоотой тээврийн үйлчилгээ үзүүлснээс үүссэн 40.7 сая төгрөгийн авлагатай байна. Үүнээс Ерөнхийлөгчийн Тамгын газар 2.7 сая, хувь хүнээс авах 0.8 сая, Төр засгийн үйлчилгээ эрхлэх газар 1.5 сая, БОНХЯ-наас авах 2.0 сая нийт 7.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
4. *Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр* худалдан авалттай холбоотой анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 12.2 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан байна.

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцов.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх 2 асуудлыг Менежментийн захидалд тусгалаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэх 2 хөтөлбөр зориулан 33,531.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 13,621.8 сая төгрөгийг урсгал зардалд, 11,881.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, 8,027.7 сая төгрөгийг гадаад зээлийн тусламжаар санхүүжигдэх зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 46 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 11,881.8 сая төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 03, 98 дугаар тушаалуудаар захиалагчийн эрхийг шилжүүлсэн ба гүйцэтгэл 10,459.8 сая төгрөг буюу 88.0 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 25,115.9 сая төгрөг буюу 74.9 хувьтай байгаа нь зарим зардлуудын санхүүжилт дутуу олгогдсон, Ухаалаг засаг төслийн зарим төслүүд хэрэгжээгүйгээс



,310.7 сая, хөрөнгө оруулалтын зардал 1,421.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтээр хандив тусламжаар 497.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 70.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 596.2 сая, нийт 1,163.2 сая төгрөгийн орлого бүрдсэнээс 997.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Харьяа байгууллагуудын өөрийн орлого 13,727.3 сая төгрөг бүрдсэнээс төсөвт байгууллагын орлого 28.6 хувь буюу 3,928.6 сая, төрийн өмчит үйлдвэрийн газруудын орлого 71.1 хувь буюу 9,758.1 сая, төслийн нэгжүүдийн орлого 0.3 хувь буюу 40.6 сая төгрөгийг эзэлж байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон харьяа байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн тайлан, мэдээг бүрэн байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмж 100 хувь биелж, 1 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувийн биелэлттэй байна. Үүнд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулсан ч эцэслэж баталгаажуулаагүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

3.2 Бэлэг дурсгалын барааны зарцуулалттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагууд гадаад дотоодын зочин төлөөлөгч, дотоод арга хэмжээнд зориулан бэлтгэсэн зарим бэлэг дурсгалын үнэ өндөр байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн



.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг үрэлгэн зарцуулах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Гадаад дотоодын зочин төлөөлөгчдөд олгох бэлэг дурсгалын үнийн хязгаарыг тогтоосон тушаал шийдвэр гарган мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,096,511.9	13,657,168.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,995,649.9	10,640,198.7
АВЛАГА	1,621,434.8	461,094.0
УРЬДЧИЛГАА	651,727.8	70,349.2
БАРАА МАТЕРИАЛ	3,827,699.4	2,485,526.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,560,307.3	62,988,598.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,560,307.3	62,988,598.6
Биет хөрөнгө	39,388,088.6	56,594,946.6
Биет бус хөрөнгө	61,419.0	6,393,652.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	110,799.8	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	53,656,819.3	76,645,766.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,362,465.9	2,392,217.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,362,465.9	2,392,217.0
Өглөг	356,738.1	309,494.2
Урьдчилж орсон орлого	2,005,727.8	2,082,722.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,294,353.3	74,253,549.9
Засгийн газрын хувь оролцоо	51,294,353.3	74,253,549.9
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	36,766,737.1	39,931,493.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0.0	3,165,985.8
Хуримтлагдсан үр дүн	6,015,966.2	4,082,217.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,511,650.0	27,073,853.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	53,656,819.3	76,645,766.9



2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	36,151,886.2	42,347,904.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,610,810.3	17,539,434.3
Нийтлэг татварын бус орлого	17,368,304.0	15,930,517.4
Хөрөнгийн орлого	682,170.3	1,065,566.3
Тусламжийн орлого	560,336.0	543,350.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,541,075.9	24,808,470.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	34,039,985.0	44,377,940.8
УРСГАЛ ЗАРДАЛ	31,252,937.4	32,790,886.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,501,838.1	30,788,009.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,407,725.3	11,342,819.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,256,385.3	1,357,148.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,201,779.0	2,309,675.2
Хангамж, бараа материалын зардал	2,971,729.0	3,591,595.9
Нормативт зардал	23,575.8	44,775.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,059,468.6	1,866,251.8
Томилолт, зочны зардал	856,157.3	1,889,288.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,466,296.1	3,570,910.3
Бараа үйлчилгээний бусад зардал	4,258,721.8	4,815,544.5
ТАТААС	85,548.0	175,473.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,665,551.3	1,827,404.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,787,047.5	11,587,054.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,111,901.3	-2,030,036.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,175.0	206,673.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	335,079.9	5,014.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,777,996.4	-1,828,377.2



3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	35,510,620.0	42,314,802.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,797,126.0	17,262,656.8
Нийтлэг татварын бус орлого	17,240,179.9	16,719,306.1
Тусламжийн орлого	556,946.1	543,350.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,713,494.0	25,052,145.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,742,727.7	28,549,264.1
УРСГАЛ ЗАРДАЛ	28,742,727.7	28,549,264.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,008,659.6	26,628,840.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,338,323.6	11,361,487.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,308,862.6	1,406,427.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,273,193.5	2,359,697.8
Хангамж, бараа материалын зардал	2,735,166.3	3,441,360.4
Нормативт зардал	58,183.8	37,117.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,298,287.1	2,188,972.9
Томилолт, зочны зардал	892,215.8	1,940,592.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,005,705.0	3,382,957.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,098,721.9	510,226.5
ТАТААС		195,675.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,734,068.1	1,724,748.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,767,892.2	13,765,538.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,391,783.3	11,289,027.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,391,783.3	11,289,027.4
Дотоод эх үүсвэрээр	5,391,783.3	11,289,027.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,391,783.3	-11,289,027.4
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-125,189.4	168,037.8
Бусад эх үүсвэр	941.6	206,345.7
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	126,131.0	38,308.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,250,919.5	2,644,548.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,744,730.4	7,995,649.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,995,649.9	10,640,198.7



4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,879,037.7	0.0	59,879,037.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-114.6	0.0	-114.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,878,923.1	0.0	59,878,923.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-12,222,414.8	0.0	-12,222,414.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,859,848.7	0.0	1,859,848.7
Тайлант үеийн үр дүн	1,777,996.4	0.0	1,777,996.4
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,294,353.3	0.0	51,294,353.3
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	51,294,353.3	0.0	51,294,353.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-105,371.1	0.0	-105,371.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51,188,982.2	0.0	51,188,982.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	18,562,202.9	0.0	18,562,202.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	6,330,742.0	0.0	6,330,742.0
Тайлант үеийн үр дүн	-1,828,377.2	0.0	-1,828,377.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,253,549.9	0.0	74,253,549.9



5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,027,868.6	2,027,868.6	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,531,285.5	25,115,868.1	-8,415,417.4	74.9
УРСГАЛ ЗАРДАЛ	21,649,527.9	14,656,097.5	-6,993,430.4	67.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,800,522.4	13,826,657.5	-6,973,864.9	66.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,093,015.7	6,067,538.2	-25,477.5	99.6
Үндсэн цалин	3,932,752.9	3,891,158.2	-41,594.7	98.9
Нэмэгдэл	1,604,498.4	1,621,407.1	16,908.7	101.1
Унаа хоолны хөнгөлөлт	474,055.2	473,263.7	-791.5	99.8
Урамшуулал	81,709.2	81,709.2	0.0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	727,343.5	700,358.3	-26,985.2	96.3
Тэтгэврийн даатгал	489,871.6	469,571.0	-20,300.6	95.9
Тэтгэмжийн даатгал	59,364.7	57,747.1	-1,617.6	97.3
ҮОМШӨ-ний даатгал	47,497.9	46,257.6	-1,240.3	97.4
Ажилгүйдлийн даатгал	11,873.5	11,555.9	-317.6	97.3
Эрүүл мэндийн даатгал	118,735.8	115,226.7	-3,509.1	97.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	951,314.5	865,951.2	-85,363.3	91.0
Гэрэл, цахилгаан	416,568.6	395,126.5	-21,442.1	94.9
Түлш, халаалт	335,541.7	306,683.1	-28,858.6	91.4
Цэвэр, бохир ус	199,204.2	164,141.6	-35,062.6	82.4
Хангамж, бараа материалын зардал	691,110.7	549,813.5	-141,297.2	79.6
Бичиг хэрэг	106,163.5	86,335.2	-19,828.3	81.3
Тээвэр, шатахуун	307,700.1	270,056.0	-37,644.1	87.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	135,172.1	78,869.7	-56,302.4	58.3
Ном, хэвлэл	2,530.6	1,371.3	-1,159.3	54.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,734.3	3,734.3	0.0	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,810.1	109,447.0	-26,363.1	80.6
Нормативд зардал	18,075.6	16,852.0	-1,223.6	93.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,990.0	1,766.8	-1,223.2	59.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,085.6	15,085.2	-0.4	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	175,973.2	173,718.9	-2,254.3	98.7
Багаж, техник, хэрэгсэл	66,141.9	65,153.9	-988.0	98.5
Тавилга	2,550.0	2,032.8	-517.2	79.7
Урсгал засвар	107,281.3	106,532.2	-749.1	99.3
Томилолт, зочны зардал	1,812,006.4	1,649,542.6	-162,463.8	91.0
Гадаад албан томилолт	847,000.0	761,632.7	-85,367.3	89.9
Дотоод албан томилолт	387,565.0	335,718.3	-51,846.7	86.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	577,441.4	552,191.6	-25,249.8	95.6



Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,815,281.5	3,600,375.4	-6,214,906.1	36.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,395,913.7	3,258,435.6	-6,137,478.1	34.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	1,000.0	0.0	100.0
Даатгалын үйлчилгээ	11,880.0	11,880.0	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	182.0	-	-182.0	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,302.1	323,868.0	-76,434.1	80.9
Газрын төлбөр	6,003.7	5,191.8	-811.9	86.5
Бараа үйлчилгээний бусад зардал	516,401.3	202,507.5	-313,893.8	39.2
Бараа үйлчилгээний бусад зардал	516,401.3	202,507.5	-313,893.8	39.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	849,005.5	829,440.1	-19,565.4	97.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	705.0	-	-705.0	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	705.0	-	-705.0	-
Бусад урсгал шилжүүлэг	848,300.5	829,440.1	-18,860.4	97.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	645,503.0	639,398.3	-6,104.7	99.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,000.0	28,980.0	-20.0	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	173,797.5	161,061.8	-12,735.7	92.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,881,757.6	10,459,770.5	-1,421,987.1	88.0
Барилга байгууламж	9,656,776.4	8,282,726.3	-1,374,050.1	85.8
Их засвар	1,511,981.2	1,467,944.3	-44,036.9	97.1
Тоног төхөөрөмж	713,000.0	709,100.0	-3,900.0	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,531,285.5	25,521,905.9	-8,009,379.6	76.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,361,045.8	23,295,523.8	-2,065,522.0	91.9
Улсын төсвөөс санхүүжих	25,361,045.8	23,295,523.8	-2,065,522.0	91.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,905,047.7	1,683,031.5	-6,222,016.2	21.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,500.0	201,420.4	58,920.4	141.3
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,762,547.7	1,481,611.1	-6,280,936.6	19.1
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	265,192.0	543,350.7	278,158.7	204.9
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	265,192.0	543,350.7	278,158.7	204.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,433,906.4	2,433,906.4	
Төсвийн тохируулгын өөрчлөлт		0.0		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6		
Төсвийн байгууллага	6	6		
АЖИЛЛАГСДЫН ТОО	566	566		
Удирдах ажилтан	22	22		
Гүйцэтгэх ажилтан	353	353		
Үйлчлэх ажилтан	85	85		
Гэрээт ажилтан	106	106		



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.04.24	Аудитын нэр:	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/6/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
I. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН					
1	Харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг баталгаажуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Г.Занданшатар
2	Харьяа байгууллагууд гадаад дотоодын зочин төлөөлөгч, дотоод арга хэмжээнд зориулан бэлтгэж байгаа зарим бэлэг дурсгалын үнэ өндөр байна.	-	Зөвлөмж өгөх	ЗГХЭГ-ын даргын Тэргүүн дэд дарга	Г.Баясгалан
	Дүн	-			
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ					
II. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР					
1	Цалингийн зардлаас тэмцээн уралдааны шагнал болон мөнгөн шагнал олгосон.	20.4	Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх зөвлөмж өгөх	ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга СХОУХ-ийн дарга	Г.Баясгалан Ж.Бямбасүрэн
2	ЗГХЭГ-ын дэд даргын 2016.09.16-ны 221 тушаалаар ажлаас халагдсантай холбогдуулан шүүхийн шийдвэрээр тогтоосон нөхөн олговрыг байгууллагын төсвөөс олгосон.	5.2	Дотоод аудитын албанд хуулийн дагуу шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын дэд дарга	Ш.Солонго
3	Гэрээт 2 ажилтанд мөнгөн урамшуулал олгосон.	1.8	Албан шаардлага хүргүүлэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын дэд дарга Санхүүгийн хэлтсийн дарга	Г.Баясгалан Ж.Бямбасүрэн
	Дүн	27.4			
III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЖЛЫН АЛБА					
1	Өмнөх оны бараа материалын зардлыг тайлант оны зардлаар тусгасан байна.	12.7	Цаашид зардлыг аккруэл сууриар зөв бүртгэж байх зөвлөмж өгөх	Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтсийн дарга Нягтлан бодогч, ахлах референт	Ж.Бямбасүрэн Д.Цэцэгмаа
2	Бэлгийн фондын бараа материалын тайланг сар бүр гаргадаггүй, бүртгэлээр хяналт сул байна.	-	Бэлэг дурсгалын бараа материалын тайланг сар бүр гаргаж, хянаж баталгаажуулж байх зөвлөмж өгөх	Санхүү хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга Нягтлан бодогч, ахлах референт	Ж.Бямбасүрэн Д.Цэцэгмаа



A	1	2	3	4	5
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд тусгасан	13.4	Цаашид бүрдэл хангасан анхан баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөх	Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтсийн дарга Нягтлан бодогч, ахлах референт	Ж.Бямбасүрэн Д.Цэцэгмаа
Дүн		26.1			
IV.МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА					
1	Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшууллыг тушаал шийдвэргүй олгосон байна.	2.2	Төсвийн шууд захирагчийн тушаалаар мөнгөн урамшууллыг олгож байх зөвлөмж өгөх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дарга Санхүүгийн хэлтсийн дарга	Г.Баясгалан Ж.Бямбасүрэн
2	Мөнгөн урамшууллыг давхардуулж олгосон.	2.0	Албан шаардлага хүргүүлэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтсийн дарга	Г.Баясгалан Ж.Бямбасүрэн
3	Шадар сайдын харьяа байгууллагуудын 11 ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо ажлын албан төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төлсөн.	1.3	Зөвлөмж өгөх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Санхүү хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтсийн дарга	Г.Баясгалан Ж.Бямбасүрэн
Дүн		5.5			
V.ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР					
1	Тус байгууллагын эзэмшил дэх агуулахыг түрээслүүлсний орлогыг дутуу төвлөрүүлсэн.	5.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Нэрж
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Нэрж
Дүн		5.5			
VI.МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ					
1	Урсгал засварын зардлын данснаас хөрөнгө бэлтгэсэн, эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй.	1.3	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
Дүн		1.3			
VII.ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХӨТӨЛБӨР					
1	Төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээг монгол хэл дээр хийгээгүй, гэрээний зарим зүйл заалт тодорхой бус байгаа нь татварын асуудал үүсэх магадлалтай.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Захиргаа, санхүүгийн ажилтан	Г.Нарангуа Ж.Золжаргал
2	Худалдан авалттай холбоотой анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан.	12.2	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Захиргаа, санхүүгийн ажилтан	Г.Нарангуа Ж.Золжаргал
Дүн		12.2			
VIII.ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ					
1	2018 онд "Монгол хьондай автоматив" ХХК-иас бусад түрээслэгчийн түрээсийн гэрээг шинэчлээгүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулаагүй, гэрээнд түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болох барьцаа хөрөнгийн талаар тусгаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал	С.Энхбаяр



A	1	2	3	4	5
2	Жилийн эцсийн байдлаар 11 байгууллага, хувь хүнтэй холбоотой тээврийн үйлчилгээ үзүүлснээс үүссэн 40.7 сая төгрөгийн авлагатай байна. Үүнээс Ерөнхийлөгчийн Тамгын газар 2.7 сая, хувь хүнээс авах 0.8 сая, ТЗҮЭГазар 1.5 сая, БОНХЯ 2.0 сая авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	7.0	Зөвлөмж өгөх	Захирал	С.Энхбаяр
3	Бараа материалын дансанд ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс бүртгэсэн байна.	60.8	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	С.Энхбаяр
4	Бэлэн мөнгөөр түрээс, гараажийн төлбөр, тээврийн хөлс, шатахууны төлөлт, цалингийн урьдчилгааны буцаан төлөлт зэрэг орлого бүрдүүлснээс кассад бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байхад харилцахаас бэлэн мөнгө авч зарцуулсан.	10.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	С.Энхбаяр
Дүн		77.8			
IX. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР					
1	Тус байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 135 дугаар тогтоолоор Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ болон өөрчлөн зохион байгуулагдсан ба санхүүгийн тайлангаа төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
2	Тус байгууллагын НБББББ-ийг 2018 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
Дүн		-			
X. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР					
1	Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан.	0.8	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Д.Нансалгарьд
2	Жолоочийн замын хуудас, тооцоо бодсон акт үйлдээгүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн.	1.0	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Д.Нансалгарьд
Дүн		1.8			
XI. ТӨР ЗАСГИЙН АМРАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР					
1	Хоол үйлдвэрлэлийн тайлан гаргаж, нэгж хоолны өртөг тооцдоггүй байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Батжаргал
2	2017 оны аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.	-	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
Дүн		-			
НИЙТ ДҮН		157.6			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 дугаар сарын 25 № 01/030
СЯГ-2019/158/СТЭ-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 211 дүгээр тушаалаар Хяналт-шалгалт үнэлгээ дотоод аудитын газрын ахлах референтийг үндэслэлгүйгээр ажлаас халсан нь шүүхээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт төсвөөс 5.2 сая төгрөгийг олгосон байна. Гэвч Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг буцаан төлүүлээгүй байна.
2. Гэрээт 2 ажилтанд 1.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиргааны ерөнхий хуулийн “103 дугаар зүйлийн 103.2-д Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасныг хэрэгжүүлэх.
2. Цаашид гэрээт ажилтанд мөнгөн урамшуулал олгохгүй байх.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



3. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Г.Баясгалан, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Бямбасүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
Ц.ХОСЖАРГАЛ
АУДИТОР
Б.УЯНГА
ХА0122

ЗӨВШӨӨРСӨН:
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА
Г.БАЯСГАЛАН
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
БЯМБАСҮРЭН
ХЯНАЛТ-ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТ-ИДЭР
YXA0054

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 дугаар сарын 25

№ 01/229

Улаанбаатар хот

ср - 2019/282/СТА - т.3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас 2.0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг эдийн засгийн ангилал зөрүүлж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2013 оны 73 тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-т "Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг бусад зардалд шилжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулахгүй байх, хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж байх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Г.Баясгалан, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Бямбасүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Ц.Хосжаргал

Ц.ХОСЖАРГАЛ

АУДИТОР

Б.УЯНГА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Г.БАЯСГАЛАН

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.Бямбасүрэн

Ж.БЯМБАСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.